

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 7327 дугаарт бүртгэв.

ЗАВХАН АЙМГИЙН БАЯНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 2 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 06

Алтай

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 62.2, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 192, А/243 дугаар тушаалын 1,2-р дугаар хавсралтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1.Сумын хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн батлагдсан үнэ тарифын дагуу иргэн, ААН, Албан байгууллага, үйлдвэр үйлчилгээний газруудаас хураан барагдуулж, орон нутгийн төсөвт цаг хугацаанд нь төвлөрүүлэх, зохих журмын дагуу зарцуулж хагас бүртэн жилээр биелэлт үр дүнг нь танилцуулж ажиллахыг сумын Засаг даргад үүрэг болгосугай.

3.Тогтоолын бүрдүүлбэрийг хангаж хууль зүйн яаманд хүргүүлж бүртгүүлэхийг Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мөнхзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Г.НАМСАН

**Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 02 дугаа сарын 07-ны өдрийн
06 дугаар тогтоолын хавсралт**

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ

Д/д	Үйлчилгээний нэр	Хэмжих нэгж /нэг сарын төлбөр/	Хураамж /төг/	Санал
1	Төвлөрсөн халаалттай орон сууцанд суугч айл өрх	Нэг сарын төлбөр	2000	
2	Галлагаатай орон сууц, гэр хорооллын айл өрх	200-ийн бочик 1 уут	3000 1500	
3	Гэр хороололд байрласан худалдааны цэг, дэлгүүр	Нэг сарын төлбөр	10000	
4	Төрлөсөн халаалттай орон сууцанд байрласан худалдааны цэг, дэлгүүр бусад	Нэг сарын төлбөр	5000	
5	Үсчин, гутал засвар, оёдолын газар, зурагчин, компьютерийн үйлчилгээний төв, талх, нарийн боов, хиам, хэрчсэн гурил, гоо сайхан, халуун ус гэх мэт	Нэг сарын төлбөр	5000	
6	Машин угаалга, машин засвар, дугуй засвар	Нэг сарын төлбөр	5000	
7	Цайны газар, Ресторан, Зочид буудал	20 хүртэл суудалтай 21 түүнээс дээш суудалтай	10000 15000	
8	Төрийн болон ТТБ	15 хүртлэх ажилтантай 15 дээш ажилтантай	5000 7500	
9	Амралт сувилалын газар	Ор тутамд /сард/	1000	
10	Мал амьтны түүхий эд авдаг цэг	Нэг сарын төлбөр	15000	
11	Мал нядалгааны цэг, бойны газар	Тоо толгой тутамд	200	
12	Шатахуун түгээх газар	Нэг сарын төлбөр	10000	
13	Хөрөө рам, модон эдлэлийн үйлдвэр, ноос эсгийний үйлдвэр	Нэг сарын төлбөр	25000	
14	Том оврын уурын зуух 9 сарын 15-аас 5 сарын 15 хүртэл	Нэг сарын төлбөр	100000	
15	Ил задгай талбайд худалдааны үйл ажиллагаа эрхлэгч, баяр наадмын үеэр барьсан гэр цэгүүд	Тухай бүр нь	10000	

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 7328 дугаарт бүртгэв.

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД,
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ**

2025 оны 7 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар А/651/983

Улаанбаатар
хот

**АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСИЙГ ШИНЭЧЛЭН
ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 72 дугаар зүйлийн 72.1.2 дахь заалт, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.3 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3, 15.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ/ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг 1 дүгээр, тухайн бүсэд мөрдөх журмыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Энэхүү тушаал, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн Ерөнхий газар (Т.Сүхболд), Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (Д.Мөнхбаатар), нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч (А.Амартүвшин)-д тус тус үүрэг болгосугай.

3.Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоосон талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлан мэдээлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хэвлэл мэдээллийн алба (Б.Батбаатар), Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс (Г.Баярцэцэг), дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4.Энэхүү хамтарсан тушаал, захирамж гарсантай холбогдуулан “Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2022 оны 10 дугаар сарын 17-ны


өдрийн А/424, А/1353 дугаар хамтарсан тушаал, захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
САЙД

Б.БАТБААТАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

[illegible][illegible][illegible]

1. *Journal of the American Medical Association*, 1964; 191: 1000-1001.

[illegible]

बिनाशितम् अस्मै

2305

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн А/651, 983 дугаар хамтарсан тушаал, захирамжийн 1 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС /2025-2026/

Дүүрэг	(Шар бүс) /Хороо/	(Ногоон бүс) /Хороо/
Сонгинохайрхан	20, 21, 22, 32, 33	1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 23, 24, 25, 26, 27, 28, 30, 31, 34, 35, 36, 39, 40, 41, 42, 43
Баянзүрх	8, 9, 10, 11, 12, 17, 19, 20, 23, 24, 28, 33, 34, 35, 37, 38	2, 21, 27, 29, 30, 31, 32
Чингэлтэй	23, 24	7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22
Сүхбаатар	16, 18, 19, 20	15, 12, 13, 14, 17
Баянгол	-	9,10, 11, 16, 21, 22, 23
Хан-Уул	9, 10, 12, 13, 14, 16, 21	4, 5, 6, 7, 8
Налайх	1, 3, 4, 5, 6, 7, 8	-
Хорооны тоо	41	67
Нийт хорооны тоо	108	
Айл өрхийн тоо	67,765	103,090
Нийт галлагаатай айл өрхийн тоо	170,855	
Тайлбар	Бусад эх үүсвэрээр үе шаттайгаар холбоно.	Бүх төрлийн хий, цахилгаан, сэргээгдэх эрчим хүч, бусад эх үүсвэрт үе шаттайгаар холбоно. /2025-2028/

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн А/651, 983 дугаар хамтарсан тушаал, захирамжийн 2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд (цаашид “Бүс” гэх)-д шинэчлэн тогтоосон мөрдөх дэглэм (стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн хэрэглэх талаар хүлээсэн үүрэг, хариуцлагыг тодорхойлох), түүхий нүүрс хэрэглэхийг хориглох, нүүрс тээвэрлэх, ашиглах зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, шингэрүүлсэн хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, журмын хэрэгжилтэд хяналт тавих төрийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн эрх, үүрэгтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Бүсэд дараах стандартын шаардлага хангасан түлш, зуух, эрчим хүчний эх үүсвэр хэрэглэнэ:

1.2.1.“ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага” MNS5216:2016 стандартыг хангасан халаалтын зуух;

1.2.2.“4.2МВт хүчин чадалтай ус халаах зуухны техникийн шаардлага” MNS5043:2016 стандартыг хангасан халаалтын зуух;

1.2.3.“сайжруулсан хатуу түлшний техникийн шаардлага” MNS5679:2022 стандартыг хангасан сайжруулсан түлш;

1.2.4.“шингэрүүлсэн нефтийн хий, ахуйн хэрэглээний түлшний техникийн шаардлага” MNS 5083:2001 стандартыг хангасан түлш;

1.2.5.нар, салхи, газрын гүний дулааныг ашиглан цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр;

1.2.6.стандартын шаардлага хангасан, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй тоног төхөөрөмж;

1.2.7.“нүүрсний чанарын ангилал” MNS 6457:2023 стандарт хангасан.

Хоёр.Иргэн, аж ахуйн нэг, байгууллагын эрх үүрэг

2.1.Бүсэд орших иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын 1.2-т зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1.бүсэд орших иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь агаар бохирдуулагч эх үүсвэрийн дэлгэрэнгүй мэдээллийг хорооны Засаг даргад мэдээллэж, хорооны Засаг дарга нэгтгэн Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын мэдээллийн санд жилд нэг удаа бүртгүүлэх;

2.1.2.сайжруулсан түлш худалдан авахдаа энэ журмын 2.1.1-д заасан шаардлагыг хангасан байх бөгөөд түлш үйлдвэрлэгчээс олгосон хяналтын картыг ашиглах;

2.1.3.эрх бүхий улсын байцаагчид болон цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, дүүргийн агаар орчны бохирдлын тасгийн алба хаагч, хорооны Засаг дарга, “Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв” ОНӨҮГ-ын ажилтны тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

2.1.4.энэ журмын 1.2.3-т заасан түлшний шаталтаас үүссэн үнсийг ахуйн хог хаягдлаас тусгайлан ангилж, битүүмжлэлтэй саванд хадгалж, зөөвөрлүүлэх;

2.1.5.бүсэд түүхий нүүрс болон зориулалтын бус түлш хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийн талаар 2.1.3-т заасан албан хаагчдад мэдээллэх;

2.1.6.гадаад, дотоод орчны агаарын бохирдлоос үүсэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалах зорилгоор зуух, яндангийн цэвэрлэгээ, засвар үйлчилгээг тогтмол хийж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр зохион байгуулж байгаа аян, сургалт, сурталчилгаанд оролцох;

2.1.7.агаар хамгаалах талаар төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллагаас мэргэжил, арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;

2.1.8.гэр, сууц, ажлын байрны дулаан алдагдлыг багасгах зориулалттай, стандартад нийцсэн нэмэлт дулаалга хийх;

2.1.9.энэ журмын 1.2.3-т заасан түлшийг аливаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага зөвхөн зөвшөөрөгдсөн бүсэд хэрэглэх ба бүсээс гаргах, бүсийн гадна худалдаалах, тээвэрлэх, ашиглахгүй байх үүрэгтэй;

2.1.10.Улаанбаатар хотыг тойрсон шалган нэвтрүүлэх цэгүүдийн гадна байрлах хороодын иргэд сайжруулсан түлш худалдан авах (тээвэрлэлт хийх) үедээ иргэний үнэмлэх болон түүнийг орлох цахим үнэмлэхээ биедээ авч явах;

2.1.11.бүс рүү нэвтрэх болон дамжин өнгөрч байгаа түүхий нүүрс, эрчим хүчний баяжуулсан нүүрс (цаашид “мидлинг” гэх(-ийг тээвэрлэж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь шалган нэвтрүүлэх цэгүүдэд үүрэг гүйцэтгэж байгаа эрх бүхий албан тушаалтанд бүртгүүлэх;

2.1.12.Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй II, III, IV цахилгаан станц, Амгалан, Сэлбэ, Налайх дулааны станц нь өөрийн хэрэгцээнд бэлтгэсэн түүхий нүүрсийг бусдад дамжуулах, худалдахгүй байх;

2.1.13.эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр түүхий нүүрсийг бүсээр дамжин өнгөрүүлэхгүй, тээвэрлэхгүй байх;

2.1.14.энэ журмын 1.2.7-д заасан баяжуулсан нүүрсийг зөвхөн байгальд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэн, технологийн зориулалтаар дулаан, уур үйлдвэрлэх зөвшөөрөл бүхий зуухнаас бусад зууханд хэрэглэхгүй, уур үйлдвэрлэхээс бусад зориулалтаар ашиглахгүй, дамжуулахгүй, худалдахгүй байх;

2.1.15.энэ журмын 1.2.4-т заасан үйлдвэрүүд, нөөцлөх агуулахууд, худалдан борлуулах цэгийн зориулалтаар ашиглаж, эзэмшиж буй газрынхаа эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, түлш хураах, хадгалах, худалдан борлуулах талбайг бетоноор цутгаж цугларсан түлшний хог хаягдлыг цэвэрлэн тогтмол зөөвөрлөж тухайн орчны эрүүл ахуй аюулгүй байдлыг хангаж хамгаалах;

2.1.16.энэ журмын 1.2.3-т заасан түлш борлуулах цэгүүд нь түлшний хог цуглуулах түр цэг байрлуулж хогийн цэгүүдэд зөөвөрлүүлэх, гэрэлтүүлэг, камержуулалт байршуулах.

2.2.Төрийн байгууллага холбогдох хууль тогтоомжид зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.1.энэ журмын 1.2.3-т заасан түлш үйлдвэрлэлийн үндсэн түүхий эдийг тээвэрлэх, бүсээр тээвэрлэн дамжин өнгөрүүлэх асуудлыг Нийслэлийн Зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн шийдвэрлэх;

2.2.2.энэ журмын 1.2.3-т заасан түлшийг дундын агуулах, борлуулалтын цэгүүд рүү түгээх, тээвэрлэх, борлуулалтын урамшуулал олгох, түүнд шаардагдах хөрөнгийг нийслэлийн жил бүрийн төсөвт тусган ажиллахыг Нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулах;

2.2.3.хяналтын картыг үйлдвэрлэх, түгээх, нөхөн олгох, хүчингүй болгох, картаар борлуулалт хийх хэмжээ, борлуулалтын давтамжийн хугацаа зэргийг түлш үйлдвэрлэгч хариуцан зохион байгуулах;

2.2.4.“Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв” ОНӨҮГ нь угаарын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр айл өрхийн яндан, зуухны бүрэн бүтэн байдлыг шалгах, засвар үйлчилгээ үзүүлэх, угаараас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж, авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газарт, Дүүргийн Засаг даргын Тамгын газарт халаалтын улирлын 14 хоног тутам ирүүлэх;

2.2.5.хууль, журмыг зөрчин тээвэрлэсэн, хадгалсан, хэрэглэсэн түүхий нүүрс, энэ журмын 1.2.3-т заасан түлш, мидлингийг хурааж, баруун бүсэд “Хэсэгчилсэн инженер хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын 24-р зуух, зүүн бүсэд Налайх дулааны станцад буулгах, заасан цэгт төвлөрүүлэх ажлыг зөрчил үйлдсэн иргэн, хуулийн этгээдийн тээврийн хэрэгслээр гүйцэтгүүлж хяналт тавин холбогдох баримт бичгийг Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газрын эрх бүхий улсын байцаагчид шилжүүлэх ажлыг Экологийн цагдаагийн

алба, үйлдсэн зөрчилд холбогдох арга хэмжээ ноогдуулж, улсын орлого болгох ажлыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын эрх бүхий улсын байцаагч гүйцэтгэх;

2.2.6.гэр хорооллын айл, өрхийг энэ журмын 1.2.3-т заасан түлшээр хангах, түгээх, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагаанд Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар хяналт тавих;

2.2.7.хатуу түлшнээс дээж авч, лабораторийн шинжилгээнд хамруулж, энэ журмын 1.2.3, 1.2.1-т заасныг хангаж буй байдалд сар тутам Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын эрх бүхий ажилтан, улсын байцаагч нар хяналт тавих;

2.2.8.шингэрүүлсэн хийн түлшнээс дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулж 1.2.4-т заасныг хангаж буй байдалд сар тутам Нийслэлийн хяналт шалгалтын газрын эрх бүхий улсын байцаагч нар хяналт тавих;

2.2.9.энэ журмын 2.1.6-д заасан аян сургалт, сурталчилгааг хамтран зохион байгуулах.

Гурав.Түүхий нүүрс болон мидлинг тээвэрлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох

3.1.Дараах эрх бүхий байгууллага зөвшөөрөл олгох, хүчингүй болгох асуудлыг зохион байгуулна:

3.1.1.Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй II, III, IV цахилгаан станц, Амгалан, Сэлбэ, Налайх дулааны станцын эрчим хүчний хэрэглээг тооцож түүхий нүүрс тээвэрлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох асуудлыг Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба хариуцах;

3.1.2.байгальд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэн дулаан, технологийн зориулалтаар уур үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын эрчим хүчний хэрэглээг тооцож, мидлинг, эрчим хүчний баяжуулсан нүүрс хэрэглэх, тээвэрлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох асуудлыг Нийслэлийн зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн зохион байгуулах;

3.1.3.бүсээр дамжин орон нутаг руу өнгөрч буй түүхий нүүрс тээвэрлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох асуудлыг Нийслэлийн зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн зохион байгуулах;

3.1.4.эрх бүхий байгууллагын хяналт, шалгалтаар 2 буюу түүнээс дээш удаа зөрчил илэрсэн тохиолдолд түүхий нүүрс болон мидлинг тээвэрлэх, ашиглах зөвшөөрлийг хүчингүй болгох.

3.2.Мидлинг тээвэрлэх зөвшөөрөл хүсэхэд дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

3.2.1.байгальд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэн технологийн зориулалтаар дулаан, уур үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар, мидлинг худалдан авах гэрээ;

3.2.2.тээвэрлэх тээврийн хэрэгслийн гэрчилгээ.

3.3.Мидлинг тээвэрлэх зөвшөөрлийн бичигт дараах мэдээллийг тусгана:

3.3.1.эрхийн бичгийн хүчинтэй хугацаа;

3.3.2.тээвэрлэх хэмжээ, тонн;

3.3.3.тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, зориулалт, даац;

3.3.4.тээвэрлэлтийн маршрут;

3.3.5.уурхайн нэр;

3.3.6.олборлогч аж ахуйн нэгжийн нэр, талбайн байршил;

3.3.7.буулгах байршлын мэдээлэл;

3.3.8.эрхийн бичиг олгосон байгууллагын мэдээлэл, огноо;

3.3.9.замын хяналтын постын баталгаажуулалтын хэсэг.

Дөрөв.Хориглох үйл ажиллагаа

4.1.Агаарын тухай хуулийн 16.1-д зааснаас гадна ногоон бүсэд дараах үйл ажиллагааг хориглоно:

4.1.1.стандартад нийцсэн бүх төрлийн хийн болон шингэн түлшнээс бусад төрлийн түлш, эд зүйл шатаах (Бүх төрлийн хатуу түлш);

4.1.2.стандартаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс давсан агаар бохирдуулагч бодис ялгаруулж байгаа автотээврийн хэрэгсэл ашиглах, тэдгээрийг өмчлөгч, эзэмшигчид автобензин, дизель түлшийг худалдан борлуулах;

4.1.3.инженерийн шугам, сүлжээнд холбогдох боломжтой байршилд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорх ус ашиглах;

4.1.4.авто сэлбэгийн задгай худалдаа үйлчилгээ эрхлэх;

4.1.5.хог хаягдал дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх, аюултай хог хаягдлын жагсаалтад орсон дахивар нөөц авах цэг байгуулах;

4.1.6.агаарын тухай хуулийн 16.1.6-д заасны дагуу экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангилал, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг борлуулах. (Тухайлбал: Евро-2, Евро-3, Евро-4 төрлийн түлш).

4.2.Шар бүсэд хамаарах хороодоос бусад хороодод энэ журмын 4.1-т заасан үйл ажиллагааг хориглоно.

Тав.Хяналт тавих

5.1.Бүх шатны Засаг дарга, эрх бүхий улсын байцаагч, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Цагдаагийн байгууллагын

албан хаагчид, Хяналт шалгалтын газар дараах хяналтыг тавина:

5.1.1.бүсэд энэ журмын 1.2.1-т заасан зуух, бага чадлын дулаан үүсгүүр, сайжруулсан шахмал түлш хэрэглэгдэж байгаа эсэх;

5.1.2.зөвшөөрөлгүй түүхий нүүрс хэрэглэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа эсэх;

5.1.3.энэ журмын 1.2.3, 1.2.4-т заасан түлш болон түүхий эдийн нөөц бүрдүүлэлт, борлуулалтын үнэ, хүргэлт, түгээлт, борлуулах үйл ажиллагаа зохих хуваарь, төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэх;

5.1.4.улс, нийслэлийн төсөв болон олон улсын хамтын ажиллагааны байгууллагын зүгээс зохих хөнгөлөлттэй үнээр, үнэ төлбөргүй олгосон цахилгаан халаагуур, гэрийн дулаалга, хийн халаагуур, сайжруулсан зуух хэрэглэж буй айл өрхийг тухайн авсан бараа, бүтээгдэхүүнээ хэрэглэж байгаа эсэх;

5.1.5.эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд болон бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэн түүхий нүүрс нэвтрүүлэх, шатаах, бусдад дамжуулах тээвэрлэх худалдаалах үйл ажиллагаа явуулж байгаа эсэх;

5.1.6.энэ журмын 1.2.3-т заасан түлшний борлуулалтыг түлш үйлдвэрлэгч хуулийн этгээдээс олгосон хяналтын картыг үндэслэн олгож байгаа эсэх;

5.1.7.бүсэд түлшний хог хаягдал, эрүүл ахуйн шаардлага, орчны аюулгүй байдал хангаж буй эсэх.

Зургаа.Тайлагнах

6.1.Энэ журмаар зохицуулагдах хуулийн этгээдүүд дор дурдсан хугацаанд холбогдох тайлан мэдээг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар нэгтгэж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт сар бүрийн 05-ны өдрийн дотор хүргүүлнэ:

6.1.1.журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага хяналт, шалгалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайланг сар тутам;

6.1.2.энэ журмын 3.1.2-т заасан зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдийн тээвэрлэсэн, нөөцөлсөн, хэрэглэсэн нүүрсний мэдээллийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба нэгтгэж сар тутам;

6.1.3.энэ журмын 1.2.3-т заасан түлшний түүхий эдийн нийлүүлэлт, нөөцлөлт, үйлдвэрлэл болон түгээлт, борлуулалттай холбоотой мэдээллийг түлш үйлдвэрлэх эрх бүхий хуулийн этгээд 14 хоног тутам;

6.1.4.энэ журмын 1.2.3-т заасан түлш үйлдвэрлэхтэй холбоотой мэдээллийг үйлдвэрлэгч, тээвэрлэлт, хэрэглээний талаарх мэдээллийг түлш үйлдвэрлэгч хуулийн этгээд тухай бүр.

Долоо.Хүлээх хариуцлага

7.1.Энэ журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай болон Эрүүгийн хууль (Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг)-т заасан, төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага тус тус ногдуулна.

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД,
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ,
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар А/919/654

Баруун-Урт хот

**АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС ТОГТООХ, БҮСЭД
МӨРДӨХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ, ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотын “Агаарын чанарыг сайжруулах бүс”-ийг 1 дүгээр, бүсэд мөрдөх журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү хамтарсан тушаал, захирамжийг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газар (Г.Энхмөнх), журмын хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Сүхбаатар аймгийн Байгаль орчны газар (Ш.Нямхүү), Ус, цаг уур орчны шинжилгээний төв (Х.Энхбаяр), Баруун-Урт хотын Засаг дарга (Ж.Жавхаатөгс)-д тус тус даалгасугай.

3.Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоосон талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлан мэдээлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хэвлэл мэдээллийн алба (П.Нансалмаа), Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Амарзаяа)-д тус тус үүрэг болгосугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
САЙД

С.ОДОНТУЯА

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

М.ИДЭРБАТ

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Сүхбаатар аймгийн Засаг даргын хамтарсан 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/919, 654 дүгээр тушаал, захирамжийн 1 дүгээр хавсралт

БАРУУН-УРТ ХОТЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС

Агаарын чанарыг сайжруулах бүс	Бүсэд хамрагдах газрын байршил, багууд	Айл өрх	Аж ахуйн нэгж, байгууллага
Баруун-Урт хотын төв орчмын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага	1, 2, 3, 4, 5, 6, 7, 9 дүгээр баг	1858	52
Нийт		1858	52

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Сүхбаатар аймгийн Засаг даргын хамтарсан 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/919, 654 дүгээр тушаал, захирамжийн 2 дугаар хавсралт

БАРУУН-УРТ ХОТЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэм, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээг тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү журмыг Баруун-Урт хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд ажиллаж, амьдарч байгаа иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

Хоёр.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

Баруун-Урт хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд ажиллаж, амьдарч буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд нь агаар бохирдуулагч аливаа эх үүсвэр ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ Ус цаг уур, орчны шинжилгээний төвөөр дүгнэлт гаргуулан Баруун-Урт хотын Засаг даргаас зөвшөөрөл авах.

2.2.Агаарын чанарын талаарх мэдээлэл болон агаар орчны бохирдлыг бууруулах зорилгоор агаар, орчныг бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах.

2.3.Агаарын бохирдлын сөрөг нөлөөллөөс эрүүл мэндээ хамгаалах зорилгоор айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд зуух, яндангийн цэвэрлэгээ, засвар үйлчилгээг тогтмол хийж дотоод орчны агаарын чанараа сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

2.4.Агаарын чанарыг сайжруулах бүсэд аймаг, сумаас зохион байгуулж буй сургалт, сурталчилгааны ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд идэвхтэй оролцох.

2.5.Агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны талаар Байгаль орчны газар сумын Засаг даргын Тамгын газарт үнэн зөв мэдээлэх.

2.6.Үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллага халаалтын зууханд хаягдал дугуй, ашигласан масло, хуванцар хог, нийлэг уут гэх мэт зориулалтын бус түлш шатаахгүй байх.

2.7. Агаарын чанарыг сайжруулах бүсэд 15 кВт-аас дээш хүчин чадалтай агаар бохирдуулах эх үүсвэр шинээр байгуулахгүй байх.

2.8. Уурын болон усан халаалтын зуух хэрэглэдэг аж ахуйн нэгж, байгууллагууд стандартын шаардлага хангасан үнс баригч, шүүлтүүртэй зуух суурилуулах, үнсийг ахуйн хог хаягдлаас тусгайлан ангилж, битүүмжлэлтэй саванд хадгалж, ачиж тээвэрлэхдээ тоосжилт дарах /чийгшүүлэх/ арга хэмжээ авах.

2.9. Агаарын чанарыг сайжруулах бүсэд 101 кВт-с дээш халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагууд технологийн шинэчлэл хийж бохирдлыг бууруулах тоног төхөөрөмжөөр (тортог баригч, шүүлтүүр, утаа сарниулагч суурилуулах, зуухны янданг боломжит хамгийн өндөр хэмжээнд хүртэл өндөрлөх гэх мэт) тоноглох.

2.10. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах иргэн 5-аас доошгүй, аж ахуйн нэгж, байгууллагууд хүний тоогоор 10-аас доошгүй мод бутыг жил бүр өөрийн эзэмшил, өмчлөлийн талбайд тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

2.11. Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд ариун цэврийн байгууламжаа нүхэн жорлон, угаадасны нүх, техникийн шаардлага MNS 5924:2015 стандартад нийцүүлэн, хөрс бохирдуулагч нүхэн жорлонгоос татгалзах.

2.12. Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрхүүд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвших.

2.13. Байгаль орчны байцаагч, орчны эрүүл ахуйн байцаагч болон цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, байгаль орчны мэргэжилтнийг шаардлагатай тохиолдолд өөрийн эзэмшилд нэвтрүүлж, түүний тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх.

2.14. Уурын болон усан халаалтын зуух ашиглагч аж ахуйн нэгж, иргэн халаалтын зуухны утааны сувагт хаягдал утааг хэмжих зориулалттай сорьцын цэг гаргаж жилд 1-ээс доошгүй удаа эх үүсвэрийн шинжилгээ хийлгэж стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг хянах.

2.15. Гэр, сууц, ажлын байрны дулаан алдагдлыг багасгах зориулалттай, стандартад нийцсэн нэмэлт дулаалга хийх.

2.16. Хуульд заасан бусад эрх, үүрэг.

Гурав. Төрийн байгууллагуудын чиг үүрэг

3.1. Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотын Засаг дарга энэхүү журмын хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

3.2. Байгаль орчны газар, Баруун-Урт хот нь агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын хэрэгжилтэд хяналт тавина.

3.3.Ус, цаг уур, орчны шинжилгээний төв агаарын чанарын хяналт шинжилгээг тасралтгүй явуулж, олон нийтийг агаарын чанарын мэдээллээр хангана.

3.4.Түүхий нүүрсний хэрэглээг үе шаттай бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй байгалийн хий болон цахилгаан халаалтыг өргөнөөр нэвтрүүлэхийг сурталчлан таниулах, сургалт сурталчилгаа хийх ажлыг эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллага болон Баруун-Урт хотын ЗДТГ-аас зохион байгуулах.

3.5.Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгжүүдийг нэгдсэн халаалтын системд үе шаттай холбогдох.

3.6.Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд өдөр шөнийн 2 тарифт тоолуур суурилуулах, шөнийн цагаар түүхий нүүрс түлэхээс татгалзаж, цахилгаан халаагуур болон бусад дэвшилтэд технологи бүхий бүтээгдэхүүн (гэр, байшин барилгын дулаан алдагдлыг багасгах, сайжруулсан зуух, түлш, сэргээгдэх эрчим хүч, хийн түлш гэх мэт)-ийг хэрэглээндээ үе шаттайгаар нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.

3.7.Багийн Засаг дарга нар агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрх болон үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийг гаргаж, дүн мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвд хүргүүлнэ.

3.8.Байгаль орчны газар “Агаарын тухай хууль тогтоомж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр баримталж буй төрийн бодлого, шийдвэр”-ийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлага, мэдээллээр хангаж ажиллана.

3.9.Өвлийн улиралд бага насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, өндөр настнуудад дотоод орчны агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, зөв дадал, хэрэглээг хэвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг Эрүүл мэндийн газар, сумын Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар хамтран зохион байгуулна.

3.10.Хотын тохижилт, үйлчилгээний газар гэр хорооллын айл өрхийн ангилан ялгасан үнс, ахуйн хог хаягдлыг гарагийн хуваарийн дагуу ангилж тээвэрлэнэ.

3.11.Байгаль орчны газар холбогдох байгууллагуудаас мэдээ тайланг нэгтгэн жил бүрийн 5 дугаар сарын 20-ны дотор Аймгийн Засаг даргын тамгын газарт тайлагнана.

Дөрөв.Хяналт, хариуцлага

4.1.Энэхүү журмын хэрэгжилтэд Сүхбаатар аймгийн Байгаль орчны газар болон эрх бүхий албан тушаалтан, сум, багийн Засаг

дарга, хэсгийн ахлагч нар хяналт тавина.

4.2.Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай болон Эрүүгийн тухай хууль (Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг), төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага ногдуулна.

ӨМНӨГОВЬ АЙМАГ БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 5/3

Баян-Овоо сум

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАР ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.1, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Малчин болон мал бүхий этгээдийн амьжиргааг дэмжих зорилгоор 2025 оны малын тоо толгойд ногдуулах малын тоо толгойн албан татварын хэмжээг төрөл тус бүрд 0 (тэг) төгрөг байхаар шинэчлэн тогтоосугай.

2. Батлагдсан тогтоолыг зохих хууль журмын дагуу холбогдох газарт бүртгүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (О.Оргилсайхан)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 14/10 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.СОНИНБАЯР

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 7331 дүгээрт бүртгэв.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЖАВХЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 38

Жаргалант

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ БОЛОН ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН ҮНИЙН ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиггаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 , 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.2.1, 9.2.2 дэхь заалт, “Аргачлал батлах тухай” Сангийн сайд, Байгаль орчины сайдын хамтарсан 2018 оны 07 дугаар сарын 19 ны өдрийн 192, А/243 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал”, 2 дугаар хавсралтаар баталсан “Энгийн хог хаягдалыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх зардлын нэгж тарифыг тооцох аргачлал”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Айл өрхөөс авах хог хаягдлын үйлчилгээний хураамжийн үнийн тарифыг 1 дүгээр хавсралтаар, аж ахуйн нэгж, байгууллагаас авах хог хаягдлын үйлчилгээний хураамж, хог хаягдлыг цуглуулах, зөөж тээвэрлэх зардалын нэгж тарифыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Үнийн тарифыг мэдээллийн бүх хэлбэрээр иргэдэд сурталчлах арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг дарга /Ж.Отгондалай/-д даалгасугай.

3.Энэхүү тогтоолыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, захиргааны хэм хэмжээний актын эмхтгэлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдсүгэй.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан 2013 оны 7 дугаар сарын 24-ны өдрийн 14 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

М.БАТЖАРГАЛ

**Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 7 дугаар сарын 02-ны
өдрийн 38 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт**

**Жавхлант сумын нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлын
үйлчилгээний хураамжийн хэмжээ /сараар/**

№	Үйл ажиллагааны чиглэл	Үнэ тариф /төгрөг/	Тооцох нэгж, хугацаа
А.Айл өрх			
1	Айл өрхүүд /малчин, мал бүхий өрх болон гэр хорооллын нийт өрхүүд/	3000	Сар бүр
Б.Худалдаа үйлчилгээний чиглэлийн аж ахуйн нэгж байгууллага, эрхлэгч иргэд			
2	Зоогийн газар, кафе, цайны газар, үсчин, гоо сайхан, зурагчин, нийтийн халуун ус, алт мөнгөний дархан, барьцаалан зээлдэх үйлчилгээ, машин угаалга, шатахуун түгээх станц, сэлбэгийн болон барилгын гэх мэт дэлгүүр, эдгээртэй адилтгах бусад	10000	Сар бүр
3	Бар, караоке, зочид буудал, амралтын газар, хоёрдогч түүхий эдийн цэг гэх мэт эдгээртэй адилтгах бусад	15000	Сар бүр
4	Гутал засвар, ил задгай төрөл бүрийн худалдаа, дугуй засвар, канон, компьютер, интернэтийн газар, оёдлын газар, шуудан холбоо, фитнес төв, биллиард, теннис, комиссын бараа болон эдгээртэй адилтгах бусад	5000	Сар бүр
5	Хүнсний ногоо, махны худалдаа ба эдгээртэй адилтгах бусад	8000	Сар бүр
6	Найман нэрийн хүнсний дэлгүүр эдгээртэй адилтгах бусад	Энгийн	Сар бүр
		24 цагийн	Сар бүр
		Хүнсний бөөний төв, худалдааны төв	1 м² /сар бүр/
В.Төрийн болон бусад байгууллагууд			
7	Боловсрол, соёлын байгууллага	20000	Сар бүр
8	Эрүүл мэндийн байгууллага	30000	Сар бүр
9	Эмийн сан	15000	Сар бүр
10	Нутгийн удирдлагын байгууллага	20000	Сар бүр
11	Мал эмнэлгийн байгууллага	6000	Сар бүр
12	Олон нийтийн байгууллага ба бусад	5000	Сар бүр
13	Хууль сахиулах, хүчний байгууллагын салбар	10000	Сар бүр
14	Банк, банк бус санхүүгийн байгууллага ба бусад	15000	Сар бүр
Г.Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж буй нэгж салбар байгууллагууд			
15	50-аас доош ажиллагсадтай үйлдвэр	35000	Сар бүр
16	Мужаан цех	10000	Сар бүр
17	Хэрчсэн гурил, талх, нарийн боовны үйлдвэр /цех/	5000	Сар бүр

18	Мод, модон материалын үйлдвэр	50000	Ажилласан сард
19	Газар тариалан	40000	
20	Бага оврын уурын зуух	30000	
21	Дулааны станц	50000	
22	Өвс хадлан бэлтгэл, жимс бэлтгэл	10000	Тухай бүр
Е.Бусад			
23	Албан байгууллага, ажлын өрөө	15000	Сар бүр
24	Цахилгаан дамжуулах болон түгээх сүлжээ	15000	Сар бүр
25	Аялагч, амрагчид /амрлалтын газарт бууснаас бусад/	5000	Тухай бүр

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 7 дугаар сарын 02-ны
өдрийн 38 дугаар тогтоолын
2 дугаар хавсралт*

Хог хаягдлыг цуглуулах, зөөж тээвэрлэх зардлын нэгж тариф

№	Зардлууд	Мазда өөрөө буулгагч машин	Нэг удаагийн тээвэр, устгалын зардал /төгрөг/	Тайлбар
1	Тэвшний хэмжээ	Өргөн нь 1.6 м, рт нь 3.1 м, тэвшний өндөр 0.1 м, багтаамж нь 2.0 тонн	2 тн	Машиныг 2013 оны 7 сард авсан.
2	Түлшний хэмжээ	1 рейс хийхэд 5 литр дизель түлш зарцуулах	18250	1 литр түлшний үнэ 3650 төгрөг
3	Техникийн элэгдлийн зардал	Өөрийн өртөг 21000000 төгрөг жилд элэгдэл буюу 10% нь 2100000	8000	Урсгал завсарын зардал 2100000 төгрөг, масло болон бусад зардал гаргах
4	Хөдөлмөр хамгааллын зардал	Хоногт бээлий 2 ширхэг, 1 удаагийн маск 2 ширхэг, ажлын нормын зуны хувцас, тээврийн хэрэгсэл арчих материал	3000	Бээлий 1000 төгрөг, маск 500 төгрөг, нормын хувцас 120000
5	Техникийн урсгал засвар	2013 оны 7 дугаар сард авсан машин	-	Жилд 2100000 төгрөг зарцуулах
Нэг удаагийн цуглуулах, зөөж тээвэрлэхэд гарах зардал			29250	-

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 7332 дугаарт бүртгэв.

ТӨВ АЙМАГ АРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 6 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 03

Аргалын Уул

ХУРААМЖ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 7 дугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Аргалант сумын хог хаягдлын төлбөр хураамж”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Аргалант сумын айл өрх, байгууллагаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, ачиж буулгах хураамж”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.


2.Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг хагас бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг сумын Засаг дарга (Я.Энхбаатар)-д үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолын нэг, хоёрдугаар хавсралтуудыг дагалдах материалуудын бүрдлийг хангуулан холбогдох байгууллагуудад хянуулж нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын бүртгэлд бүртгүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дарга (Р.Алтанзул)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Э.НЯМДОРЖ

[illegible][illegible][illegible][illegible]

L ନିଜସ୍ଵାଧିକାର ସମାପ୍ତ ହେବା ପରେ

2023/08/20

200

[illegible][illegible]

*Сумын ИТХ-ын 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн
07 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралт*

АРГАЛАНТ СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛБӨР ХУРААМЖ

Д/д	Хог хаягдал гаргагч эх үүсвэр			Хэмжих нэгж	Хураамжийн хэмжээ /төг/
1	Иргэн			Сард	500
2	Төсөвт байгууллага			Сард	10,000
3	Банк			Сард	5,000
4	Зочид буудал			Сард	5,000
5	Баяр наадам, шоу цэнгүүн зохион байгуулагчид			Тухай бүр	50,000
6	Шатахуун түгээх станц			Сард	20,000
7	Дэлгүүр			Сард	5,000
8	Цайны газар			Сард	5,000
9	Халуун ус, үсчин, гутал засвар, оёдлын газар, бусад			Сард	5,000
10	Барилгын хог хаягдал			1тн	5.000
11	Авто болон дугуй засвар, угаалга			сард	10,000
12	Газар тариалан эрхлэгч иргэн			Жилд	60,000
13	Газар тариалан эрхлэгч ХХК			Жилд	180,000
14	Уурын зуух, үнс	Ажиллаж буй саруудад		сард	50,000
15	Мал нядалгааны цэг,	Тухай бүр	Бод	1 толгойд	300
			Бог	1 толгойд	200
16	Суурьшлын бүсэд байгаа гэрийн тэжээмэл амьтад	Гахай	Нэг толгойд	сард	1,000
		Тахиа, шувуу	Нэг толгойд	сард	100
17	Мал эмнэлэг			сард	5.000
18	Мал амьтаны түүхий эд авах цэг			сард	10,000
19	Агуулах, зоорь			сард	10,000
20	Амралт, аялал жуулчлалын хээрийн түр кемп иргэн			хоногт	2,000
21	Үсчин гоо сайхан массажны газар			сард	10,000
22	Ил задгай талбайд худалдааны үйл ажиллагаа эрхлэгч, дэлгүүр, баяр наадмын үеэр барьсан цайны газар, бусад цэгүүд			сард	10,000
23	Аялал, жуулчлал, Амралт сувиллын байгууллагын хог хаягдал			сард	20,000
24	Оршуулгын газар			Сар	100,000
25	Өөх тос, махны үйлдвэр			Сар	100,000
26	Нүүрс худалдаалагч иргэд /9 сараас дараа оны 4 сар дуустал/			сард	30,000

*Сумын ИТХ-ын 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн
07 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолын 02 дугаар хавсралт*

**АРГАЛАНТ СУМЫН АЙЛ ӨРХ, БАЙГУУЛЛАГААС ГАРАХ ХОГ
ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, АЧИЖ БУУЛГАХ ХУРААМЖ**

Д/д	Хог хаягдлын хэмжээ	Түлшний зардал	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
1	Шуудай хог	Захиалагч түлш өөрсдөө хариуцана.	1,000
2	Нэг тонн хогийг тээвэрлэх зардал		15,000
3	Хогийн машинаар /Зтн/ түлш		45,000
4	Ковш хог түрэх булшлах мот/цаг түлш		100,000
5	Өвөлжөө бууц түрэх өдрийн		400,000

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 7333 дугаарт бүртгэв.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 5 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар IV/03

Хөхөө

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 62 дугаар зүйлийн 62.2, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, Сангийн сайд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн батлагдсан үнэ, тарифын дагуу иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллага, үйлдвэр, үйлчилгээний газруудаас хураан барагдуулж орон нутгийн төсөвт цаг хугацаанд нь төвлөрүүлэх, зохих журмын дагуу зарцуулж, бүтэн жилээр биелэлт үр дүнг нь танилцуулж ажиллахыг сумын Засаг дарга (Д.Болд-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын бүрдүүлбэрийг хангаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж бүртгүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Баярцэцэг), байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга (Б.Батжаргалд) нарт үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ тогтоох тухай” 06 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Баярцэцэг)-д даалгасугай.

ДАРГА

Х.ЭНХТҮВШИН

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит
IV дугаар хуралдааны IV/03 тогтоолын хавсралт*

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

№	Үйлчилгээний төрлүүд	Хэмжих нэгж	Хураамж /мян. төгрөг/
Хог хаягдлын үйлчилгээний хураамж			
1	Аж ахуйн нэгж, албан байгууллагууд, хувираа хөдөлмөр эрхлэгч	Сар бүр	8000
2	Жуулчны бааз, амралтын газар	Ажилласан сараар	10000
3	Ил задгай талбайд худалдаа үйлчилгээ эрхлэгч дэлгүүр, баяр наадмын талбайн цайны газар	Тухай бүр	10000
4	Өрх бүр (иргэн бүрийн тоогоор тооцно)	Сар бүр	500
5	Барилгын хог хаягдал	1 тн тутамд	8000
6	Хөрөө рам, модон эдлэлийн үйлдвэр	Сар бүр	13000
7	Сумын төв доторх малтай өрх	Жилд	30000

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНМӨНХ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 25-ний өдөр

Дугаар 01

Улаан эрэг

МАЛЫН ТОО ТОЛГОЙД НОГДОХ АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48 дугаар зүйлийн 48.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4-р хуралдаанаас ТОГТООХ нь :

1.Сумын нутаг дэвсгэрт дагаж мөрдөгдөх малын тоо толгойд ногдох албан татварын хувь хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Малын тоо толгойн албан татварыг хуульд заасан хугацаанд орон нутгийн төсөвт төвлөрүүлж Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д заасан үйл ажиллагаанд зарцуулан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг дарга /О.Нямдаваа/-д, Татварын орлого төвлөрүүлэлтэнд хяналт тавин ажиллаж, тайланг бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг татварын улсын байцаагч /Э.Өсөхжаргал/-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төсөв санхүү, эдийн засгийн хөгжил, хот суурин, дэд бүтцийн хөгжлийн хороо /Б.Алтантуяа/, Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороо /Э.Бат-Эрдэнэ/, шийдвэрийг иргэд, олон нийтэд сурталчилан танилцуулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг хүчингүй болсон тооцсугай

ДАРГА

С.БАДАМГАРАВ

*Хэнтий аймгийн Баянмөнх сумын иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн
6 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолын хавсралт*

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ

д/д	Малын тоо толгойн албан татвар / тоо толгойд ногдох /		0 төгрөгт ногдох албан татвар /малчны амжиргааг дэмжих зорилгоор/	
	Төрөл	Татвар	Төрөл	Тоо толгой
1	Тэмээ	500	Тэмээ	5
2	Адуу	1000	Адуу	10
3	Үхэр	800	Үхэр	10
4	Хонь	500	Хонь	100
4	Ямаа	500	Ямаа	50

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

НЭРИЙН ДАНСНЫ 2024 ОНЫ ОРЛОГОД ТООЦОХ ХҮҮГИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-ын 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 11.34 хувиар тогтоосугай.

2. Баталсан хүүгийн хэмжээг үндэслэн даатгуулагчдын тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2023 оны үлдэгдэл, 2024 оны орлогод тус тус хүү тооцох ажлыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулж, даатгуулагчдыг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Б.Батжаргал)-т үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын алба (Г.Банзрагч)-нд даалгасугай.

ДАРГА

Т.АУБАКИР

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 7336 дугаарт бүртгэв.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

НАС БАРСАН ДААТГУУЛАГЧИЙН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНД ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 3,000,000 (гурван сая), амьгүй донор болж эс, эд, эрхтэнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 4,500,000 (дөрвөн сая таван зуун мянга) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.

2.Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Б.Батжаргал)-т үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг ажлын алба (Г.Банзрагч)-нд даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны “Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай” 08 дугаар тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА

Т.АУБАКИР

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар
хот

СЭРГЭЭН ЗАСАХ БОЛОН СУВИЛЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.9.8 дахь заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг нэг ор хоногт 110,000 (нэг зуун арван мянга) төгрөгөөр тогтоосугай.

2.Энэхүү тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас сэргээн засах болон сувиллын байгууллагуудад олгож буй санхүүжилт, үйлчилгээний чанарт тогтмол хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Б.Батжаргал)-т үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын алба (Г.Банзрагч)-нд даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Т.АУБАКИР

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 12 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.16 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1.14 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.7, 60.3, 60.5 дахь хэсэг Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.6 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 192, А/243 дугаар хамтарсан тушаал, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны А/82 дугаар тушаалыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит II хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад дараах өөрчлөлтийг оруулсугай.

1.1. 2.2. “8 нэрийн хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 50 мк² хүртэл/ 100,000 төгрөг” гэснийг “8 нэрийн хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 50 мк² хүртэл/ 70,000 төгрөг” гэж;

1.2. 2.3. “8 нэрийн хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 51-200 мк² хүртэл болон Супермаркет/ 130,000 төгрөг” гэснийг “8 нэрийн хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 51-200 мк² хүртэл болон Супермаркет/ 90,000 төгрөг” гэж;

1.3. 2.6. “Хүнсний зах 150,000 төгрөг /нэг рейсийн үнэ/” гэснийг “Хүнсний зах 200,000 төгрөг /нэг рейсийн үнэ/” гэж;

1.4. 2.7. “Барааны зах 150,000 төгрөг /нэг рейсийн үнэ/” гэснийг “Барааны зах 200,000 төгрөг /нэг рейсийн үнэ/” гэж;

1.5. 2.8. “Их дэлгүүр 2,000,000 төгрөг” гэснийг “Их дэлгүүр 200,000 төгрөг /нэг рейсийн үнэ/” гэж;

2.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 6.3.“Банк, Банк бус санхүүгийн байгууллагууд салбар бүрээр” гэсний “Банк бус санхүүгийн байгууллагууд салбар бүрээр” гэснийг хассугай.

3.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад 6.3.1.“Банк бус санхүүгийн байгууллагууд салбар бүрээр 70,000 төгрөг” гэж нэмсүгэй.

4.Энэ тогтоолын нэмэлт, өөрчлөлтийг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, сурталчлан таниулж, дагаж мөрдүүлэхийг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д үүрэг болгосугай.

5.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА

Т.УЛАМБАЯР